

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/27.

Арвайхээр сум

┌ Байгууллагын эд хөрөнгийн Улсын үзлэг, ┐
тооллого зохион байгуулах комисс
томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4, 71. 72.1.2.4, 73 дугаар зүйл, Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн “Төрийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай 238 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын тооллогын ажлыг зохион байгуулах тухай” А/323 дугаар захирамжийн 4 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Дуламсүрэн (НЭМХ-ийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичиг: М.Мөнхбаатар (Эдийн засагч)

Гишүүд:

Б.Оюунчимэг (Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл сургалт,
сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн)

Э.Одбаяр (Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хүртээмж
хариуцсан ажилтан)


П.Цэнгэлбаяр (Олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан)

Э.Ганбаяр (Жижүүр)

2.Эд хөрөнгийн тооллогыг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулж, нүдээр үзэн чанартай хийж, гүйцэтгэхийг комиссын дарга (С.Дуламсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Н.ОЮУНТУЯА

622331030

My.Doc.Tushaal. EMG